



**ЦУС СЭЛБЭЛТ СУДЛАЛЫН
ҮНДЭСНИЙ ТӨВИЙН ЗАХИРЛЫН
ТУШААЛ**

2013 оны 10 сарын 11 өдөр

Дугаар A/67

Улаанбаатар хот

**"Нэгдсэн менежментийн тогтолцооны бодлого"-ыг
шинэчлэн батлах тухай**

"Алсын хараа 2050" Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлого, ЦССҮТ-ийн Бүтэц, үйл ажиллагааны стандарт 6674:2017, Дунд хугацааны стратеги төлөвлөгөөг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Цус сэлбэлт судлалын үндэсний төвийн "Нэгдсэн менежментийн тогтолцооны бодлого"-ыг хавсралтаар баталсугай.

2. Нэгдсэн менежментийн тогтолцооны бодлогын хэрэгжилтийг ханган ажиллахыг төвийн албаны дарга, тасгийн эрхлэгч нарт, тайланг жил бүр төвийн Удирдлагын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэхийг Цусны чанар, аюулгүй байдлын албаны дарга /А.Амарзаяа/-д тус тус үүрэг болгосугай.

3. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Дотоод аудитор /С.Алтаннамар/-т даалгасугай.

ЕРӨНХИЙ ЗАХИРАЛ



Н.ЭРДЭНЭБАЯР

1260010842

НЭГДСЭН МЕНЕЖМЕНТИЙН ТОГТОЛЦООНЫ БОДЛОГО

Нэг. Үндэслэл

ISO 9001:2015 Чанарын менежментийн тогтолцооны стандартын 5.2 Бодлого, 5.2.1 Чанарын бодлого боловсруулах, дээд удирдлага нь а) байгууллагын зорилго, төлөв байдалд тохирсон, стратегийн чиглэлийг дэмжих, б) чанарын зорилтуудыг бий болгох, боломжоор хангах, с) холбогдох шаардлагыг биелүүлэх үүргийг тусгах d) чанарын менежментийн тогтолцоог үргэлж сайжруулах үүргийг тусгасан чанарын бодлогыг бий болгож, хэрэгжүүлж мөрдөх, 5.2.2 Чанарын бодлогыг мэдээлэх а) баримтжуулсан мэдээлэл байдлаар хүртээмжтэй байх ба мөрдөж хадгалах,

ISO 45001:2018 Хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй байдлын менежментийн тогтолцооны стандартын 5.2 ХЭМАБ-ын бодлогыг дээд удирдлага бий болгох, хэрэгжүүлэх, хэрэгжилтийг хангах, а) байгууллагын зорилго, цар хэмжээ, төлөв байдал болон ХЭМАБ-ын эрсдэл ба боломжуудын онцлог шинж чанарт тохирсон, гэмтэл ба эсвэл эрүүл мэндийн хохирлоос сэргийлэхийн тулд ажлын аюулгүй, эрүүл нөхцлөөр хангах үүрэг амлалт, б) ХЭМАБ-ын зорилтуудыг тогтоохуйц агуулга, хүрээтэй байх с) хууль тогтоомжийн шаардлага болон бусад шаардлагыг биелүүлэх үүрэг амлалт, d) аюулыг арилгах ба ХЭМАБ-ын эрсдлийг бууруулах үүрэг амлалт, e) ХЭМАБ-ын менежментийн тогтолцоог байнгын сайжруулах үүрэг амлалт, f) ажилтнуудын, хэрэв байгаа бол тэдний төлөөллийн оролцоог хангах ба зөвлөлдөх үүрэг амлалт, ХЭМАБ-ын бодлого нь баримтжуулсан мэдээлэл байх гэж тус тус шаардсаныг үндэслэн энэ бодлогыг боловсрууллаа.

Хоёр. Хамрах хүрээ

Цус цуглуулах, шинжлэх, цус, цусан бүтээгдэхүүн үйлдвэрлэх, хадгалах, олгох, сургалт, зөвлөгөө болон эдгээрийг дэмжих бүхий л үйл ажиллагааг хамруулна.

Гурав. Бодлого

Төвийн дунд хугацааны хөгжлийн хөтөлбөрт нийцүүлэн, чанарын болон хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн менежментийн тогтолцоо (Цаашид Нэгдсэн менежментийн тогтолцоо гэх)—г байнга сайжруулж, аюулыг илрүүлэн, эрсдлийг бууруулж, үйлчлүүлэгч, ажиллагсдад ээлтэй орчинг бүрдүүлнэ.

Дөрөв. Зорилго, зорилт

4.1 Нэгдсэн менежментийн тогтолцооны стандартын шаардлагыг хангаж, сонирхогч талуудын хэрэгцээ шаардлагад нийцсэн тусламж үйлчилгээ үзүүлж, тасралтгүй сайжруулах

4.1.1. ISO 9001:2015 Чанарын менежементийн тогтолцоо, ISO 45001:2018 Хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй байдлын менежментийн тогтолцооны стандартуудын дотоод аудитыг жил бүр 1-ээс доошгүй удаа зохион байгуулж, илэрсэн үл тохирол, сайжруулах зөвлөмжийн дагуу залруулах арга хэмжээг заавал авч ажиллана.